СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 19 өдөр Дугаар 34 Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 39 дүгээр зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Ш.Мөнхжаргалаас Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл, гомдлыг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ёндонжамц -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд:

Б.Мөнхзул -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Б.Ариундэлгэр -Хүний нөөцийн мэргэжилтэн, Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

2.Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж, дүгнэлт, санал боловсруулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2018 оны 11 дүгээр сарын 27-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Ёндонжамц)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ө.СУВДАА